

МОНГОЛ-ХЯТАДЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА: БОЛОМЖ БА СОРИЛТ

*Д. Шүрхүү**

“Монгол-Хятадын эрчим хүчний хамтын ажиллагаа: боломж ба сорилт” хэмээх энэхүү өгүүлэлдээ түлш, эрчим хүчний салбар Монгол-Хятадын харилцааны тэргүүлэх чиглэл болон гарч ирж буй тухай, хоёр орны эрчим хүчний салбар дахь хамтын ажиллагааны өнөөгийн байдал, үр дүн, мөн цаашдын хэтийн төлвийг тодорхойлж буй эерэг, сөрөг хүчин зүйлс зэрэг асуудлуудыг голлон тусган харуулахыг зорилгоо.

1. Эрчим хүчний салбар - Монгол-Хятадын харилцааны тэргүүлэх чиглэл

БНХАУ-ын дарга Ху Жинтао 2003 онд Монгол Улсад төрийн айлчлал хийх үеэр найрсаг харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагаагаа бүх талаар хөгжүүлэх зорилгоор Монгол, Хятадын сайн хөршийн харилцан итгэсэн түншлэлийн харилцааг тогтоон хөгжүүлэхээ хоёр орны удирдагчид албан ёсоор мэдэгдсэн билээ. Хоёр тал худалдаа, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжиж, уул уурхайн болон боловсруулах үйлдвэрлэлийн салбар дахь хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, байгалийн баялгийг ашиглах, дэд бүтцийг хөгжүүлэх явдлыг хоёр улсын цаашдын хамтын ажиллагааны чухал салбар болгохоор тохиролцов. Үүний эхлэл болгож Хятадын тал Монгол Улсад 300 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл олгохоор амласан билээ.

Энэ үеэс хойш Монгол-Хятадын өндөр, дээд хэмжээний айлчлалын үеэр уул уурхай, эрчим хүчний хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудал яриа хэлэлцээний хамгийн чухал сэдвийн нэг болсон төдийгүй айлчлал бүр ямар нэг түвшинд тодорхой шийдэл тохиролцоонд хүрч байв.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр 2005 онд БНХАУ-д төрийн айлчлал хийх үеэр “Монгол Улсын ТЭХЯ, БНХАУ-ын Улсын хөгжил, шинэчлэлийн хорооны хооронд түлш, эрчим хүчний салбарт хамтран ажиллах тухай санамж бичиг”, “Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Экспорт-Импорт банкны хоорондын 300 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн Ерөнхий хэлэлцээр”, “Монгол Улсын Төвийн бүсийн цахилгаан сүлжээ төрийн өмчит хувьцаат компани, БНХАУ-ын Улсын цахилгаан сүлжээний корпораци хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг” зэрэг эрчим хүчний салбарт өргөн хүрээтэй хамтын ажиллагааны эхлэлийг тавьсан чухал баримт бичгүүдэд гарын үсэг зуржээ.

* Д.Шүрхүү - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболд 2006 оны 11-р сард БНХАУ-д албан ёсны айлчлал хийх үеэр хоёр тал худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хамгийн чухал салбар болж буй дэд бүтэц, эрчим хүчний салбаруудад эхэлсэн хамтын ажиллагааг цаашид Монгол Улсад цахилгаан станц, авто зам, төмөр зам барих талаар хамтран ажиллах замаар үргэлжлүүлэн хөгжүүлэх хүсэл эрмэлзлээ нотолсон билээ.

БНХАУ-ын Дэд дарга Си Зинпин 2008 оны 6-р сард Монгол Улсад айлчлах үеэр Хятадаас сар бүр 10.000 тн газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх, бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ/-ний дагуу Монгол Улсын Тамсаг, Зүүнбаянгийн сав газраас олборлож, Хятад руу гаргаж буй түүхий газрын тосноос Монголын талд ногдох хувьтай дүйцэхүйц хэмжээний бензин шатахууныг импортоор авах, Монгол Улс гуравдагч орноос авахаар төлөвлөж буй түүхий газрын тосыг Хятадын үйлдвэрт боловсруулан татваргүйгээр оруулж ирэх асуудлыг Монголын тал дэвшүүлсэн бөгөөд Хятадын тал судлан үзэж, нааштайгаар шийдвэрлэхэд анхаарч ажиллахаа илэрхийлсэн байна.

Энэ оны 4-р сард БНХАУ-д ажлын айлчлал хийх үеэр Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр, Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Зябао нар уулзахдаа нэмүү өртөг шингээсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглэн цахилгаан эрчим хүчний цогцолбор барьж БНХАУ-д цахилгаан эрчим хүч экспортлох, нүүрснээс газрын тосны бүтээгдэхүүн болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр хамтран ажиллах талаар хөндөн ярилцаж, Монгол Улсын Эрдэс баялаг, эрчим хүчний яам, БНХАУ-ын Хөгжил шинэчлэлийн хорооны хооронд “Эрдэс баялаг, эрчим хүчний салбарт хамтран ажиллах тухай Монгол, Хятад хоёр улсын засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах тухай протокол”-д гарын үсэг зурав.

Хоёр орны харилцаанд уул уурхай, түлш, эрчим хүчний салбар тэргүүлэх байр суурь эзлэх болсонтой уялдан худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэлд ч ихээхэн өөрчлөлт гарч байна. Тухайлбал, 1990-2004 онуудад Хятад улс нийтдээ 441 сая ам.долларын хөрөнгө оруулж байсан бол зөвхөн 2006-2007 онуудад 511 сая ам.долларын хөрөнгө оруулсаны ихэнх нь геологи, уул уурхай, газрын тосны эрэл хайгуул, олборлох салбарт орсон байна. 1990-2004 онуудад хөрөнгө оруулалт худалдаа, нийтийн хоолны салбарт түлхүү орж байсан бол 2005 оноос хойш геологи, уул уурхайн салбар тэргүүлэх байр суурийг баттай эзлэх болсон бөгөөд 2007 оны байдлаар БНХАУ-ын нийт хөрөнгө оруулалтын 60 орчим хувь нь Монголын уул уурхайн салбарт орсон тухай статистикийн мэдээ гарчээ.

Монгол-Хятадын худалдааны эргэлт сүүлийн 10 жилийн дотор бараг 20 дахин нэмэгдэж, 1998 онд дөнгөж 143 сая ам.доллар байсан


худалдааны эргэлт 2008 онд 2.8 тэрбумыг даваад байна.¹ Экспорт, импортын энэхүү огцом өсөлтийн нэлээд хувийг нүүрс, түүхий газрын тос, бензин шатахуун, шатдаг хий, цахилгаан эрчим хүч гэх мэт түлш, эрчим хүчний холбогдолтой бараа бүтээгдэхүүний худалдаа бүрдүүлсэн бөгөөд цаашид ч энэ хандлага улам нэмэгдэх төлөвтэй байна.

Хоёр орны удирдлагын дээд түвшинд эрчим хүчний чиглэлээр харилцан ашигтай хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх, идэвхижүүлэх хүсэл сонирхол нэгтэй байгаа болон хамтын ажиллагааны томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр нухалтгай хэлэлцэж буй байдал, худалдаа, хөрөнгө оруулалтын чиг хандлага зэрэг бүхий л нөхцөл байдлыг харгалзан тооцвол ойрын жилүүдэд түлш, эрчим хүчний салбар Монгол-Хятадын харилцаанд тэргүүлэх байр суурь эзлэх нь илэрхий байна.

2. Монгол-Хятадын эрчим хүчний хамтын ажиллагааны өнөөгийн байдал

Сүүлийн жилүүдэд Монгол, Хятад хоёр орон түлш, эрчим хүчний хамтын ажиллагаа, ялангуяа газрын тос, нүүрс, байгалийн хий гэх мэт эрчим хүчний түүхий эдийн геологи, хайгуул, олборлолтын чиглэлээр эрс идэвхижив.

Газрын тос. Монгол Улсын газрын тосны хайгуул, олборлолтонд БНХАУ-ын хөрөнгө оруулалттай компаниуд давамгайлж байна. Хятадын хөрөнгө оруулалттай “Петрочайна Дацинь Тамсаг /Монгол/” ХХК Тамсагийн сав газрын Тосон-Уул-ХИХ (2010 онд дуусна), Буйр-XXII (2010), Тамсаг-XXI (2012), Дуншен Газрын Тос /Монгол/ ХХК Зүүнбаян-ХИХ (2010), Цагаан-Элс-ХИХ (2010), “Чайна голден сий петролиум эксплорэйшн корпорэйшн” Дорноговийн сав газар дахь Тариач-ХУ (2011) хайгуулын талбайнуудад тус тус хайгуул судалгааны ажлыг идэвхитэй явуулж байна.



Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газраас гаргасан дүн мэдээгээр 2008 онд газрын тосны хайгуулд оруулсан хөрөнгө оруулалт 2007 оныхоос 2.5 дахин нэмэгдсэний ихэнхийг дээрх 3 компани гаргасан бөгөөд нийт 210 орчим үнэлгээний цооног өрөмджээ.²

Одоогоор “Петрочайна Дацинь Тамсаг /Монгол/” Тосон-Уул-ХИХ, “Дуншен Газрын Тос /Монгол/” Зүүнбаян-ХИХ, Цагаан-Элс-ХИХ ордуудаас туршилтын олборлолт явуулж байна. Тус хоёр компани 2008 онд 1126.0 мянган баррель газрын тос олборлож, 101.7 сая ам.долларын өртөг бүхий 1053.8 мянган баррелийг экспортонд гаргасан байна. Энэ нь 2007 онтой харьцуулбал биет хэмжээгээр 30%, үнийн дүнгээр 90% өссөн ажээ.³

“Петрочайна Дацинь Тамсаг /Монгол/” ХХК-ний дэд захирал Жао Жэнлунь “Монголын мэдээ” сонинд өгсөн ярилцлаганаас үзэхэд 2009 оны хувьд тус компани дэлхийн эдийн засаг, санхүүгийн хямралаас үүдсэн багагүй саад бэрхшээлтэй тулгарч байгаа ажээ. Хямралын улмаас туршилтын олборлолт явуулдаг 73 цооногоос 47-ыг хааж, өдөрт 600 тонн тос олборлон зах зээлд нийлүүлэх төлөвлөгөөтэй боловч одоогоор ердөө 300 тонн борлуулахад хүрчээ. Гэхдээ энэ онд тус компани хөрөнгө оруулалтыг 500 сая ам.долларт хүргэж, Монголоос 500, Хятадаас 4000 ажилчин авч ажиллуулахаар Монголын АМГТХЭГ-тай гэрээ байгуулан ажиллаж байна.⁴

Нүүрс. Монголоос хамгийн ойрын үед их хэмжээгээр олборлон, экспортоор гаргах боломжтой ашигт малтмал бол Хятадад жилээс жилд импортоор авах эрэлт хэрэгцээ нь өсч буй нүүрс юм. Тийм ч учраас Монголд нүүрсний орд газрыг нээх, нүүрс олборлох, гүн боловсруулах, экспортлох явдал нь Монгол-Хятадын эрчим хүчний салбарын хамтын ажиллагааны ихээхэн ирээдүйтэй, далайцтай чиглэлийн нэг юм.

Одоогийн байдлаар нүүрсний салбарт хамгийн идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй Хятадын хөрөнгө оруулалттай компани бол “Чинхуа-МАК-Нарийн Сухайт” ХХК юм. Тус компани нь Шивээ хүрэнгийн боомтоос 50 км зайд орших 230 сая тонн сайн чанарын нүүрсний нөөц бүхий Нарийн Сухайтын нүүрсний ордын тодорхой хэсэгт олборлолт явуулах зорилгоор 2002 оны 10 дугаар сард үүсгэн байгуулагджээ. Хамтарсан компани 2003 оноос нүүрс олборлолтоо эхэлсэн бөгөөд жилд дунджаар 1.5 сая тн нүүрс Хятадад экспортолж байна. Үүнээс гадна Нарийн Сухайтын нүүрсний ордын лицензийг эзэмшиж буй Монголын МАК компани 2008 оны эхээр бие даан 1.5 сая тонн хүчин чадалтай шинэ ил уурхайг нээж, Хятад руу экспорт хийж эхлэв. Цаашдаа төмөр замын барилгын ажил дуусмагц хүчин чадлыг 3 сая тоннд хүргэхээр төлөвлөжээ.⁵

Үүнээс гадна Монголын “Тавантолгой”, Канадын “Соутгоби ресорсис” компаниуд жилд 0.8-1.0 сая тн орчим нүүрс олборлон Хятад руу гаргаж байна.

2008 оны байдлаар Монгол Улс нийт 186.4 сая ам.долларын өртөг бүхий 4.16 сая тн нүүрс гол төлөв БНХАУ руу экспортолсон нь 2007 оны үзүүлэлтээс тоо хэмжээгээр 27.5% /3.26 сая тн/, үнийн дүнгээр 58.9% /116.2 сая ам.доллар/ өссөн дүн гарчээ.⁶

Газрын тосны бүтээгдэхүүний импорт. Монгол Улс 2008 онд 834.0 мянган тонн газрын тосон бүтээгдэхүүнийг 870.0 сая ам.доллараар худалдан авсаны дотор 92%-ийг ОХУ-аас, 5.8%-ийг БНХАУ-аас оруулжээ. Монголын засгийн газраас газрын тосны бүтээгдэхүүний импортын 30-иас доошгүй хувийг өөр эх сурвалжаас хангах зорилт дэвшүүлэн ажилласны дүнд Хятадаас бензин, шатахуун авах хэмжээ нэмэгдэж байна. БНХАУ-ын Дэд дарга Си Зинпин 2008 оны 6-р сард Монгол Улсад айлчлах үеэр Хятадаас сар бүр 10.000 тн газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлж байх асуудлыг манай талаас тавьсаныг нааштай хүлээн авсан билээ. Хоёр талын холбогдох байгууллагууд яриа хэлэлцээ хийсний дүнд 2008 оны 8-р сараас эхлэн сар бүр РОН-90, РОН-93 маркийн автобензинийг 10 000 тн, үүнээс баруун, зүүн бүсээр тус бүр 1000 тонн РОН-90, Замын-Үүдээр 8000 тн РОН-93 автобензин авахаар тохиролцсон байна. Гэвч баруун зүүн бүсийн боомтуудаар шатахуун хүлээн авах нөхцөл хараахан бүрдээгүй, Хятадын тал одоогоор нийлүүлэх бололцоогүй хэмээн мэдэгдсэний улмаас зөвхөн төвийн бүсээр 16 000 тонн РОН-93 автобензинийг улсын нөөцийн зориулалтаар хүлээн авсан байна.⁷

Цахилгаан станц барих. Сүүлийн жилүүдэд Монгол-Хятадын эрчим хүчний хамтын ажиллагааны чухал чиглэл бол бага дунд оврын усан цахилгаан станц барих явдал юм. Монгол Улсын баруун бүс цахилгаан эрчим хүчний ихээхэн дутагдалтай байдлыг өөрчлөхийн тулд Монголын засгийн газар дотоод, гадаадын эх санхүүжилтийн үүсвэрт түшиглэн Ховдын Дөргөн, Говь-Алтайн Тайширт бага оврын /11-12 МГвт хүчин чадалтай/ 2 УЦС барихаар шийдвэрлэсэн юм. Энэ хоёр УЦС барихад Хятадын компаниуд голлох үүрэг гүйцэтгэсэн юм. Тайширын УЦС нь Кувейтын сан, Абу-Дабигийн хөгжлийн сан болон Монголын засгийн газрын хөрөнгөөр боссон бөгөөд барилга, угсралтын ажлыг Хятадын усан цахилгаан станцын барилгын компани /中国水利水电建设集团/ хариуцан гүйцэтгэсэн бол Дөргөний УЦС-ыг Шанхайн СФЕКО групп Хятадын зээлээр барьж босгож байна.

Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр саяхан БНХАУ-д айлчлах үедээ урьд өмнө хэлэлцэж байсан Шивээ-Овоогийн нүүрсний ордыг түшиглэн томоохон дулааны цахилгаан станц барих, Хятад руу

цахилгаан эрчим хүч экспортлох ажлыг хэрэгжүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлсэн бөгөөд 2009 оны 5 дугаар сарын эхээр Шивээ-Овоогийн орд газрыг түшиглэн нүүрсний уурхай, цахилгаан станцын цогцолборыг барихтай холбогдсон асуудлыг Засгийн газрын ээлжит хуралдаанаар авч хэлэлцэв. Энэ төслийн өгөөж, үр ашгийг тооцох, хамтын ажиллагааны хэлбэрийг тодорхойлох, бүтээн байгуулалт, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэн төслийн ажлыг эрчимжүүлэхэд шаардлагатай шийдэл гаргах, холбогдох гэрээ хэлэлцээр байгуулахад хууль эрх зүй, нийгэм, байгаль орчин болон эдийн засаг, хураамжийн асуудлаар санал дүгнэлт гаргах асуудлыг хэлэлцээд ажлын хэсэг байгуулахаар болсон байна.

3. Монгол-Хятадын эрчим хүчний хамтын ажиллагааны цаашдын төлөв

Хятадын эрчим хүчний зах зээлийн эрчимтэй тэлэлт нь нүүрс, газрын тос, уран гэх мэт эрчим хүчний түүхий эдээр харьцангуй баян боловч эмзэг, жижиг эдийн засагтай Монгол Улсад асар их боломж олгохын зэрэгцээ түүнээс дутахгүй сорилт, аюул, болгоомжлолыг агуулж байна.

Монгол, Хятадын эрчим хүчний салбар дахь хамтын ажиллагаа дээр дурдсан чиглэлүүдээр уул уурхай, эрчим хүчний салбар дахь хөрөнгө оруулалт, цахилгаан станцууд барих, газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх гэх мэт уламжлалт чиглэлүүдээс гадна сүүлийн үед нүүрсийг гүн боловсруулах, шингэн түлш, химийн бүтээгдэхүүн гарган авах, нар, салхи гэх мэт нөхөн сэргээгдэх эрчим хүчний салбарт хамтран ажиллах өргөн боломж нээгдэж байна.

Монгол Улс өмнөд хөрштэйгээ түлш, эрчим хүчний салбарт харилцан ашигтай хамтын ажиллагааг далайцтай хөгжүүлэх өргөн боломж, олон арга зам байгаагийн дотор нэн түрүүнд ашиглаж болох потенциал бол Хятадын асар том зах зээл юм. Юуны өмнө нүүрс, газрын тос, ураныг хамгийн том импортлогч орон Хятад, эдгээр эрчим хүчний чухал түүхий эдийн нөөцөөр баян Монгол хоёр орон энэ тал дээр харилцан нөхөх, харилцан ашигтай ажиллах асар их потенциал, өөдрөг хэтийн төлөв хүлээж байна.

Монгол Улс ойрын 3-4 жилд Хятадад экспортлох нүүрс /10-15 сая тн/, газрын тос олборлолтоо /2-3 сая баррель/ 2-3 дахин нэмэгдүүлж, 5-10 жилийн дараа уран, цахилгаан эрчим экспортолж эхлэх боломжтой хэмээн судлаач шинжээчид үзэж байна.

Хятад улс дэлхийн нүүрсний хамгийн том үйлдвэрлэгч, мөн хэрэглэгч юм. Хятадын нүүрс олборлолт 2002 онд 1.4 тэрбум тн байсан бол 2007 онд 2.5 тэрбум тн-д хүрч, сүүлийн 5 жилд дунджаар 12.4 % өсчээ.⁸ Гэсэн хэдий ч эрэлт хэрэгцээ цаашид улам өсөх хандлагатай

байгаа ажээ. Хятадын нүүрсний үйлдвэрийн холбооны тэргүүн Ван Сяньжэний ярьсанаар бол жилд 1.1 тэрбум тонн нүүрс олборлох хүчин чадал удахгүй нэмэгдэх боловч зарим жижиг уурхайнуудыг хааж байгаа тул 2010 оноос л эрэлт нийлүүлэлт тэнцвэржих болно гэжээ.⁹

Сүүлийн жилүүдэд Монгол Улсыг дэлхий дахинд хамгийн их таниулж сурталчилж буй түүхий эд бол яах аргагүй уран юм. Монгол Улс одоогоор ураны 6 орд, 100 гаруй илрэлтэй бөгөөд судлагдсан ураны нөөц 62.000 тонн, таамаг нөөц 1.3 сая тонн.¹⁰ Одоо манай улсын нутаг дээр Areva, Bluerock, Khan Resources, Mega, Western Prospector гэх мэт өрнөдийн 10 гаруй компани ураны геологичайгуулын ажлыг идэвхитэй явуулж, ойрын үед 2-3 жилийн дотор олборлолт эхэлнэ хэмээн зарлаад байна.

БНХАУ-ын хувьд атомын эрчим хүчийг ашиглах томоохон хөтөлбөрийг 2007 онд баталсан юм. Хятад улс 2020 он хүртэл 32 АЦС барихад 50 тэрбум ам доллар зарцуулахаар төлөвлөж байгаа бөгөөд зарим шинжээчид 2050 он гэхэд энэ тоо бараг 300-д хүрнэ хэмээн таамаглаж байна.¹¹ Хэдийгээр тус орны эдийн засаг сүүлийн 4 жилд хоёр оронтой тоогоор хөгжиж байгаа боловч жил бүр 2 реактор ашиглалтад оруулж, цөмийн эрчим хүчээр эрэлт хэрэгцээнийхээ дөнгөж 2.3 хувийг хангадаг байдлыг эрс өөрчлөн дэлхийн дундаж 10-15% үзүүлэлтэд хүрэх нь нэлээд цаарагай зорилт төдийгүй багагүй болгоомжлол төрүүлж байна.

Хятад улс ураны хүдрийн нөөцөөр баян биш тул цөмийн түлшний асуудлыг шийдвэрлэх амаргүй зорилт гарч ирнэ. 2020 онд Хятадын цөмийн эрчим хүчний суурилагдсан хүчин чадал 40.000 МВт хүрэх тул тэдгээрийн жилд хэрэглэх 7000-7500 тн ураныг хаанаас хэрхэн олох талаар хятадын эрх баригчид одооноос янз бүрийн арга замыг эрж хайж байна. Хятадын үндэсний цөмийн эрчим хүчний компаний /CNNC/ мэдээлснээр тус орны хамгийн том ураны ордыг Өвөр Монголын Ордос хавиас илрүүлсэн ажээ. Түүний нөөц нь 10.000 тн бөгөөд Шинжааны Ирид ч бас 17 жилийн турш эрж хайсны дүнд томоохон ураны орд илрүүлсэн тухай мэдээлэл цацагджээ.¹²

Хятадууд ойрын жилүүдэд ураны стратегийн нөөц бүрдүүлэхээр идэвхитэй ажиллаж байгаа бөгөөд Австралиас 2020 оны үед жилд 2500 тн уран авахаар яриа хэлэлцээр хийж байна. Энэ нь дээр дурдсан хятадын эрэлт хэрэгцээний 1/3-ийг хангах юм.¹³

Монгол-Хятад хоёр орон эрчим хүчний салбарт өргөн хүрээнд үр дүнтэй хамтран ажиллах асар их боломж, потенциалын зэрэгцээ геополитикийн болон зах зээлийн өрсөлдөөн, эдийн засгийн аюулгүй байдал, үнэ ханш, ажиллах хүч, байгаль орчинтой холбоотой олон асуудал бэрхшээл, сорилтуудыг хамтын хүчээр даван туулах шаардлага гарч ирж байна.

Эдгээрийн дотроос хамгийн чухал хоёр асуудал бол үнэ ханш, байгаль орчны асуудал бөгөөд хоёулаа маш эмзэг, дотоод гадаад байнга анхаарал татдаг асуудал юм. Олон талын эрх ашиг хөнөдөж байдаг тул экспортоор гаргах ашигт малтмал, эрчим хүчний түүхий эдийн үнэ ханш Монголын нийгэм-улс төрд үзүүлэх нөлөө, үр дагавар их. Сүүлийн жилүүдэд Монголын улс төрийн амьдралд хамгийн халуун сэдэв бол ашигт малтмалын томоохон орд, түүнээс олох ашиг орлогын асуудал юм. Нэг хэсэг уул уурхайн экспортын бүтээгдэхүүний үнэ маш замбараагүй байв.

Уул уурхайн экспортын бүтээгдэхүүний жишиг үнийг Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 88 дугаар тогтоолын дагуу Үйлдвэр, худалдааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 119/89 дугаар тушаалаар батласан “Уул уурхайн экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг жишиг үнэлэх арчлал”-ын 4.4-д зааснаар экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний үндэслэл болгох олон улсын жишиг үнэ тогтоодог бирж, Монголбанкны болон зах зээлийн үнийн эх сурвалжийн талаарх жишиг үнийг баримтлан тогтоож байна.

Засгийн газрын 2007 оны 88 дугаар тогтоолын дагуу БНХАУ-ын Өвөрмонголын нүүрсний үнийг баримжаалан гаргасан жишиг үнэ

| Нүүрс | | | |
|----------------------|----------------|---|------------|
| Төрөл | Ккаллор | Чанарын үзүүлэлт | Үнэ |
| Хүрэн нүүрс | 4000 | Хүхэр:0.9%, дэгдэмхий бодис: 45%, үнслэг 25% | 27.86 |
| Чулуун нүүрс | 5000-5500 | Хүхэр:0,5%, дэгдэмхий бодис: 30%-35%, үнслэг 8%-12% | 35.92 |
| Коксжих нүүрс | 6300-6500 | Хүхэр:S<1%, дэгдэмхий бодис:30%, үнслэг 11% | 49.85 |

Сүүлийн үед Хятадын батлан хамгаалах номлолд гарч буй нэг шинэ зүйл бол Бээжингийн зүгээс улам бүр илт тод зарлах болсон Хятадын хувьд амин чухал орон зай хэмээн тодорхойлж буй нутаг дэвсгэрт өрсөлдөгчөө болон тааламжтай бус орныг нэвтрүүлэхгүй байх, тогтоон барих бодлого юм. Энэ нь зөвхөн цэрэг, аюулгүй байдлын хүрээгээр хязгаарлагдахгүй, улс төр, эдийн засгийн бодлогыг хамрах ажээ. ОХУ-ын Улс төр, цэргийн шинжилгээний хүрээлэнгийн судлаач А.А.Храмчихин Хятадын арми “стратегийн хүрээ хязгаар, амин чухал эрх ашгийн орон зай” хэмээх үзэл баримтлалын дагуу

зохион байгуулагдаж байна. Энэхүү номлол хүн амын өсөлт, нөөц баялгийн хязгаарлагдмал байдал нь улс орны эдийн засгийн үйл ажиллагааг хангахын тулд орон зайгаа тэлэх жам ёсны эрэлт хэрэгцээг бий болгож байна гэдэг үзэлд тулгуурлаж буй. Ингэснээр хятадуудад цэргийн давших үйл ажиллагааг явуулах үндэслэл, зөвтгөх боломж гарч ирнэ хэмээн оросын шинжээч бичсэн байна.¹⁴ Энэ үүднээс авч үзвэл Монгол Улсад Хятадын хөрөнгө оруулалт эрс нэмэгдэн, нүүрс, газрын тос, цахилгаан эрчим хүч зэрэг амин чухал эрх ашиг бүхий салбарт өмнөд хөршийн оролцоо нэмэгдэх тусам Монгол Улс Хятадын онцгой эрх ашгийн орон зайд лавтайяа орох бөгөөд улмаар тэрхүү эрх ашгийг ямар нэг байдлаар ноцтой зөрчсөн асуудал үүсэх, аюул тулгарвал Хятадын зүгээс Монголд улс төр-дипломатын болон цэргийн талаар заналхийлэх магадлал нэмэгдэнэ хэмээн болгоомжлох үзэл хандлага Монголд өсч болзошгүй юм. Бид эхнээс нь эрчим хүчний асуудалд эрх ашгийн тэнцвэр, аюулгүй байдлын хэмжүүр, аливаа бодлого үйлдлээс гарах үр дагавраа сайтар тооцоолон, эрх зүйн зохицуулалтыг сайтар хийх нэн чухал болох нь эндээс тодорхой харагдаж байна.

Монгол-Хятадын эрчим хүчний хамтын ажиллагаа цаашид өргөжин хөгжихийн хэрээр түүнийг тойрсон олон асуудал, сорилт, бэрхшээл урган гарах нь дээр өгүүлсэн жишээ баримтуудаас тодорхой харагдаж байна. Бидний хувьд хамгийн эерэг үр дүнд хүрч болох зөв оновчтой, цогц бодлого явуулахын тулд юу хийвэл зохистой вэ гэвэл,

1-рт, Хамгийн түрүүнд хийх ёстой ажил бол дэд бүтэц, ялангуяа төмөр зам, авто замын сүлжээ нэн даруй хөгжүүлэх,

2-рт, Хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулах,

3-рт, Хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл, зарчим, бодлогоо зөв, оновчтой тодорхойлох. Хамтын ажиллагаа өрнүүлэхээр бэлтгэж буй томоохон төслүүдэд баримталбал зохих үндсэн зарчмууд бол:

- Тэргүүний технологид түшиглэсэн, байгаль экологид дээд зэргээр ээлтэй байх,

- Үйл ажиллагаа, татвар төлөлт шударга, ил тод байх,

- Эрх ашгийн тэнцвэртэй байдлыг хангах буюу аль нэг улс, компаний эрх ашиг давамгайлахаас сэргийлэх,

- Дэлхийн зах зээлийн үнийг баримжаалах зэрэг болно.

Бүс нутаг, дэлхий ертөнц эрчим хүч тээгч түүхий эдийн зах зээлийн өрсөлдөөнд автаад буй өнөөгийн нөхцөлд эрчим хүчний аюулгүй байдлаа хангах, улмаар бүс нутгийн эрчим хүчний томоохон нийлүүлэгч болох явдал бол амин чухал асуудал бөгөөд хэрэв бид дээр дурдсан тулгуур зарчмуудаа Хятад, Орос зэрэг хүчирхэг хөршүүдтэйгээ харилцахдаа тууштай баримтлан, эрчим хүчний

томоохон нийлүүлэгч болох зорилтыг ханган биелүүлж чадвал манай улсын нэр хүнд, геополитикийн байр суурь бэхжин, тусгаар тогтнол, эдийн засгийн аюулгүй байдлаа бэхжүүлэх боломжтой. Эс чадваас их гүрнүүдийн өрсөлдөөн, геополитикийн тоглоомны бай золиос болон хувирч мэдэх, тэр хэмжээгээр дотоод улс төр, эдийн засаг, байгаль экологийн гэх мэт олон аюул заналтай тулгарах болно.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны *Статистикийн бюллетень- 2008 оны 12-р сар*,
http://www.statis.mn/bull/2008/bulletin_2008_dec.pdf
2. Монгол Улсын Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын 2008 оны үйл ажиллагааны тайлан.
<http://www.mram.gov.mn/images/stories/pdf/amgtheg%202008.12.30%20tailan.pdf>
3. Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны *Статистикийн бюллетень- 2008 оны 12-р сар*, хуудас -68.
http://www.statis.mn/bull/2008/bulletin_2008_dec.pdf
4. Жао Жэнлунь: Энэ онд хайгуулын ажлаа дуусгаад албан ёсны олборлолтын шатандаа шилжсэнээ зарлахаар бэлдэж байна. Монголын мэдээ сонин, 2009.02.24 №8-9, / 赵崢伦: 今年勘探期结束以后准备宣布进入正式开采阶段。蒙古消息报 /
5. http://www.mak.mn/index.php?option=com_content&task=view&id=56&Itemid=81
6. Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны *Статистикийн бюллетень- 2008 оны 12-р сар*, хуудас -68.
http://www.statis.mn/bull/2008/bulletin_2008_dec.pdf
7. Монгол Улсын Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын 2008 оны үйл ажиллагааны тайлан.
<http://www.mram.gov.mn/images/stories/pdf/amgtheg%202008.12.30%20tailan.pdf>
8. China's coal demand in 2010 will exceed 3 billion tons. *By People's Daily Online* April 15, 2008
9. China's coal supply gets boost. *Source: Shanghai Daily*
10. С.Баяр и С.Кириенко Проработают совместные планы. Монцэмэ, 2008-05-26
11. China Embraces Nuclear Future. Optimism Mixes With Concern as Dozens Of Plants Go Up By Ariana Eunjung Cha , *Washington Post*, Tuesday, May 29, 2007; D01
12. Мөн тэнд
13. Мөн тэнд
14. А.А.Храмчихин Угроза, которая сама по себе “не рассосется” - Китай неизбежно ломает нынешний мировой порядок.